



07

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/275

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геодезийн хэмжил зүйн лабораторид тохируулга, баталгаажуулалт хийлгэх "Геодези, зураг зүйн хэмжлийн багаж хэрэгслийг түр хадгалах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны А/305 дугаар тушаалаар батлагдсан "Тээвэрлэх, хадгалах журам"-ын хоёрдугаар бүлгийг хүчингүй болгосугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Архив, мэдээллийн төв /Н.Адилбиш/-д, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т тус тус даалгасугай

ДАРГА

Ц.ГАНХҮҮ



08 192175

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газрын даргын 2019 оны 11 дугаар
дугаар тушаалын хавсралт



ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭМЖЛИЙН БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ ТҮР ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь геодезийн хэмжил зүйн лабораторид тохируулга, баталгаажуулалт хийлгэхээр ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн геодези, зураг зүйн хэмжлийн багаж хэрэгслийг түр хадгалах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Багаж хэрэгслийг хадгалах

3.1. Геодези, зураг зүйн багаж хэрэгслийг лабораторид хүлээн авч, шалгаж, тохируулсны дараа бүртгэлийн мэдээллийн санд тухайн багаж шалгагдаж баталгаажигдсан тухай мэдээллийг оруулан бүртгэж, эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нэр, утасны дугаар, хаягийг тодорхой бичиж багажны хайрцагт нааж эзэмшигчийг багажаа буцаан авах хүртэлх хугацаанд хадгална.

3.2. Геодезийн хэмжил зүйн лаборатори нь үйлчлүүлэгчийн багажийг хадгалах зай талбай ихтэй, гэрэлтүүлэг сайтай, хүлээн авсан багажуудыг тавих бат бөх тавиур бүхий тусгай өрөөтэй байна.

3.3. Шалгагдсан багажуудыг төрөл, тохируулга, баталгаажуулалт хийгдсэн байдал, хугацаа зэргээр ангилан, ангиллын дагуу лабораторийн хадгалах өрөөний тавиурт эмх цэгцтэй, хаягийг нь ил харагдахаар зөв байрлуулна.

Гурав. Багаж хэрэгслийг хадгалах хугацаа, төлбөр тооцоо

3.1. Шалгалт, тохируулгад хамрагдсан багаж хэрэгслийг иргэн, хуулийн этгээд хүлээн авах хүртэл лабораторид 30 хоногийн хугацаанд үнэ төлбөргүй хадгална.

3.2. Заасан хугацаанд иргэн, хуулийн этгээд багаж хэрэгслийг аваагүй тохиолдолд мэдээллийн санд бүртгэгдсэн утас, хаягаар холбогдож мэдэгдэх, албан бичиг явуулах зэрэг арга хэмжээг авах бөгөөд холбогдож чадаагүй, багаж эзэмшигч иргэн, хуулийн этгээдээс хариу ирээгүй тохиолдолд уг багажийг 5 жилийн хугацаанд хадгална.

3.3. 5 жилийн хугацаанд ашиглагдах боломжтой багажийг эзэмшигч ирж аваагүй тохиолдолд тухайн багажийг хадгалсан хугацааны төлбөрт тооцон байгууллагын өмчид бүртгэж авах болно.

3.4. Шалгалт, тохируулга, баталгаажуулалтад хамрагдсан багаж хэрэгслийг энэхүү журмын 3.1-д заасан хугацаанаас хойш хадгалсан тохиолдолд төлбөрийг өдрөөр тооцож баталгаажилтын төлбөр дээр нэмж төлнө.

3.5. Шалгалт, тохируулга, баталгаажуулалтад хамрагдсан багаж хэрэгслийг журмын 3.1-д заасан хугацаанаас хэтэрсэн тохиолдолд бүх төрлийн нивелирийн хадгалах нэг өдрийн төлбөр нь 1000 төгрөг, бүх төрлийн электрон теодолит, электрон тахеометрийн хадгалах нэг өдрийн төлбөр нь 3000 төгрөг байна.

3.6. Төлбөрийг төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Устгалд оруулах

4.1. Иргэн, хуулийн этгээдийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэхээр өгсөн геодези, зураг зүйн хэмжлийн ашиглах боломжгүй багаж хэрэгслийг Геодезийн хэмжил зүйн лабораторид түр хадгалах хугацаа дууссан тохиолдолд устгалд оруулна.

4.2. Жил бүрийн 11 дүгээр сард геодезийн хэмжил зүйн лабораторийн багаж хадгалах өрөөнд хадгалагдаж байгаа 5 жил ба түүнээс дээш хугацаагаар хадгалагдсан багажны жагсаалтыг гаргаж багаж эзэмшигч иргэн, хуулийн этгээдэд устгалд оруулах тухай мэдэгдлийг журмын 3.2-д заасны дагуу хүргүүлнэ.

4.2. Багаж эзэмшигч иргэн, хуулийн этгээдэд багаж устгах тухай мэдэгдсэний дараа “Байгууллагын устгалын байнгын комисст”-т мэдээллийг хүргүүлж тухайн комиссын шийдвэрийг үндэслэн устгуулна.

Тав. Бусад

5.1. Багаж хэрэгслийг хадгалах хугацаа, төлбөр болон устгах тухай мэдээллийг багаж хүлээн авч буцаан олгох хуудасны санамж хэсэгт заасан бөгөөд эзэмшигч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ хийж баталгаажуулна.

5.2. Багаж хэрэгслийг хадгалах өрөөнд зөвхөн лабораторийн ажилтнууд нэвтрэх ба тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, багаж хэрэгсэл хадгалах зааварчилгааг мөрдөж ажиллана.

5.3. Багаж хэрэгслийг хадгалах өрөө нь галын аюулаас сэргийлэх, галын дохиоллын систем мөн гал унтраах хэрэгсэлтэй байх ба ажилтнууд онцгой байдлыг үед ажиллах дадлага эзэмшсэн байна.

- 000 -

